

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.9. Аудитын илрүүлэлт.....	19
Залруулсан алдаа.....	19
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	20
Аудитын зөвлөмж.....	21
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	21
4. Менежментийн захидал	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	25



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ Э.ГАЛБАДРАХ ТАНАА

2021.08.25 № 07/557

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Гэмтэл согог судлалын үндэсний төв” -ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол “Гэмтэл согог судлалын үндэсний төв”-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сувилахуйн тусламж үйлчилгээний 1 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.5 хувь, Хүний нөөцийг хөгжүүлэх ажлын гүйцэтгэлийн үнэлгээг шинэчлэх 1 зорилгын 27 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95 хувийн биелэлттэй 2 зорилт бүрэн хэрэгжүүлээгүй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 697,129.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс 393,058.3 мянган төгрөгөөр давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн

тархаагүй, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх”, “Үнэн зөв байдал”, “Толилуулга ба тодруулга”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант он: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,413,098,831.37	1,683,599,876.41
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,000,000.00
31100	Кассад байгаа бэлэн мөнгө	-	2,000,000.00
33	АВЛАГА	2,380,000.00	48,139,744.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	602,284.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,380,000.00	7,537,460.00
33500	Бусад авлага	-	40,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,410,718,831.37	1,633,460,132.41
35100	Түүхий эд материал	404,349,742.47	351,035,053.71
35110	Тусгай зориулалттай материал	133,531,649.38	63,356,609.37
35130	Эм боох материал	270,818,093.09	287,678,444.34
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	69,488,975.34	133,875,073.43
35300	Бэлэн бүтээгдэхүүн	649,763,049.78	738,481,329.66
35400	Хангамжийн материал	287,117,063.78	410,068,675.61
35410	Бичиг хэргийн материал	7,947,540.00	23,908,797.61
35420	Аж ахуйн материал	47,708,179.99	80,837,959.84
35440	Түлш, шатах тослох материал	21,606,948.02	22,219,537.57
35450	Барилгын засварын материал	49,755,370.00	132,209,881.00
35460	Хүнсний материал	9,948,585.77	40,965,784.59
35470	Бусад хангамжийн материал	150,150,440.00	109,926,715.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	20,955,164,463.90	28,160,869,284.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20,955,164,463.90	28,160,869,284.67
39200	Биет хөрөнгө	20,032,152,686.59	27,239,277,544.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	18,790,945,784.01	18,790,945,784.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	(395,820,229.24)	(737,730,266.32)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	309,907,995.33	254,088,541.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(273,773,266.13)	(91,731,818.66)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	11,522,576,125.44	11,520,201,720.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(10,156,952,012.13)	(2,927,885,888.43)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	530,330,450.62	502,986,272.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	(327,278,936.39)	(87,953,000.06)
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,622,900.00	23,622,900.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,399,343.92)	(7,266,699.84)
39217	Ном	14,993,219.00	-
39300	Биет бус хөрөнгө	923,011,777.31	921,591,740.00
39301	Программ хангамж	7,256,000.00	7,256,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,310,000.00)	(2,310,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	935,344,140.00	939,244,140.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(17,278,362.69)	(22,598,400.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	22,368,263,295.27	29,844,469,161.08
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,380,000.00	7,537,460.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,380,000.00	7,537,460.00
41300	Өглөг	2,380,000.00	7,537,460.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	3,879,000.00
41360	Бусад өглөг	2,380,000.00	3,658,460.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	22,365,883,295.27	29,836,931,701.08
51	Засгийн газрын хувь оролцоо	22,365,883,295.27	29,836,931,701.08
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,974,253,679.78	9,974,253,679.78
51200	Хуримтлагдсан үр дүн	(3,595,526,594.49)	4,383,584,867.48
51210	Өмнөх үеийн үр дүн	(2,021,261,318.17)	(3,087,463,538.33)
51220	Тайлант үеийн үр дүн	(1,574,265,276.32)	7,471,048,405.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,987,156,209.98	15,479,093,153.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	22,368,263,295.27	29,844,469,161.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант он: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	30,407,158,577.18	41,118,121,245.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,288,663,339.90	9,927,625,904.98
120	Нийтлэг татварын бус орлого	3,288,663,339.90	9,906,877,704.98
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,959,287,341.90	4,727,925,033.72
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,900,624,095.53	4,633,771,636.77
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	58,663,246.37	94,153,396.95
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	152,532,970.00	3,845,807,997.23
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	176,843,028.00	1,333,144,674.03
122	Тусламжийн орлого	0	20,748,200.00
122001	Хандив тусламж /дотоод/	0	20,748,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	27,118,495,237.28	31,190,495,340.61
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,698,239,700.00	10,890,778,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,698,239,700.00	10,890,778,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	666,632,419.28	228,991,005.61
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	61,004,250.00	28,060,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	133,683,000.00	126,329,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	471,945,169.28	74,602,005.61
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,753,623,118.00	20,070,726,235.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,753,623,118.00	20,070,726,235.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	31,862,129,034.30	36,622,472,198.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,862,129,034.30	36,622,472,198.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,635,711,468.55	36,177,453,905.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,382,160,220.00	11,397,131,967.79
210101	Үндсэн цалин	5,442,632,720.00	7,103,935,276.21
210102	Нэмэгдэл	2,579,728,500.00	2,507,214,915.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	880,075,000.00	781,379,311.00
210104	Урамшуулал	479,724,000.00	1,004,602,465.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,224,310,699.00	1,479,816,356.00
210201	Тэтгэврийн даатгал	836,127,900.00	1,010,114,522.00
210202	Тэтгэмжийн даатгал	93,078,799.00	138,426,388.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	78,694,400.00	91,304,972.00
210204	Ажилгүйдлийн даатгал	19,673,600.00	21,816,040.00
210205	Эрүүл мэндийн даатгал	196,736,000.00	218,154,434.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	687,331,328.88	741,889,265.01
210301	Гэрэл, цахилгаан	425,516,330.03	423,406,896.27
210302	Түлш, халаалт	135,446,493.07	155,892,047.38
210303	Цэвэр, бохир ус	126,368,505.78	162,590,321.36
2104	Хангамж, бараа материалын зардал	569,839,089.60	446,995,483.09
210401	Бичиг хэрэг	43,952,423.01	43,642,489.00
210402	Тээвэр, шатахуун	75,190,862.85	50,268,460.45
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	23,440,045.00	28,366,543.37
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	157,834,756.00	194,851,809.47
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	269,421,002.74	129,866,180.80
2105	Норматив зардал	4,882,168,477.03	7,008,411,972.41
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,183,259,642.01	6,182,480,649.23

210502	Хоол, хүнс	633,465,535.00	677,196,539.18
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	65,443,300.02	148,734,784.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,121,991,811.00	1,100,638,465.67
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,567,000.00	98,001,913.12
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,923,500.00	33,926,200.00
210604	Урсгал засвар	1,114,501,311.00	968,710,352.55
2107	Томилолт, зочны зардал	35,971,800.00	11,490,000.00
210702	Дотоод албан томилолт	35,971,800.00	11,490,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	110,535,770.00	217,529,943.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,299,360.00	149,833,650.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,000,000.00	12,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,925,900.00	3,323,735.19
210804	Тээврийн хэрэгслийн татвар	725,800.00	755,724.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0	166,386.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	2,997,300.00
210807	Газрын төлбөр	7,868,400.00	7,620,188.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	90,300.00	72,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	39,626,010.00	40,760,560.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,621,402,273.04	13,773,550,452.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,364,977,802.23	12,732,599,826.08
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,221,424,470.81	1,040,950,626.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	226,417,565.75	445,018,292.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	177,157,738.19	240,448,752.58
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	158,517,738.19	213,631,732.58
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,640,000.00	26,817,020.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	49,259,827.56	204,569,540.35
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,389,119.30	204,569,540.35
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(1,454,970,457.12)	4,495,649,047.32
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0	4,066,371,547.48
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	0	4,066,371,547.48
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	119,294,819.20	1,090,972,188.99
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0	236,326.84
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	119,294,819.20	1,090,735,862.15
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(1,574,265,276.32)	7,471,048,405.81

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант он: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	30,122,782,579.18	35,920,800,374.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,959,287,341.90	4,727,925,033.72
120	Нийтлэг татварын бус орлого	2,959,287,341.90	4,727,925,033.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,959,287,341.90	4,727,925,033.72
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,900,624,095.53	4,633,771,636.77
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	58,663,246.37	94,153,396.95
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	27,163,495,237.28	31,192,875,340.61
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,698,239,700.00	10,890,778,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,698,239,700.00	10,890,778,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	711,632,419.28	231,371,005.61
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	61,004,250.00	28,060,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	178,683,000.00	128,709,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	471,945,169.28	74,602,005.61
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,753,623,118.00	20,070,726,235.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,753,623,118.00	20,070,726,235.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,858,533,264.18	35,603,366,345.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29,858,533,264.18	35,603,366,345.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,629,735,698.43	35,156,751,052.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,382,160,220.00	11,243,106,507.79
210101	Үндсэн цалин	5,442,632,720.00	6,026,289,387.68
210102	Нэмэгдэл	2,579,728,500.00	3,441,196,977.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	880,075,000.00	808,269,081.51
210104	Урамшуулал	479,724,000.00	967,351,060.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,224,310,699.00	1,634,264,100.00
210201	Тэтгэврийн даатгал	836,127,900.00	1,148,541,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	93,078,799.00	121,430,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	78,694,400.00	97,144,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	19,673,600.00	24,286,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	196,736,000.00	242,861,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	687,331,328.88	741,889,265.01
210301	Гэрэл, цахилгаан	425,516,330.03	423,406,896.27
210302	Түлш, халаалт	135,446,493.07	155,892,047.38
210303	Цэвэр, бохир ус	126,368,505.78	162,590,321.36
2104	Хангамж, бараа материалын зардал	418,002,022.00	441,802,549.78
210401	Бичиг хэрэг	42,269,733.00	52,621,686.61
210402	Тээвэр, шатахуун	88,546,012.00	53,285,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	23,438,505.00	28,366,543.37
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	161,753,946.00	169,134,198.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	101,993,826.00	138,394,771.80
2105	Норматив зардал	5,083,079,198.42	6,853,668,120.92
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,345,395,986.42	6,060,845,512.92
210502	Хоол, хүнс	636,008,377.00	707,512,738.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	101,674,835.00	85,309,870.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,354,149,606.68	1,168,721,542.55
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,799,000.00	31,491,050.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	12,179,500.00	34,827,200.00
210604	Урсгал засвар	1,340,171,106.68	1,102,403,292.55
2107	Томилолт, зочны зардал	35,971,800.00	11,490,000.00
210702	Дотоод албан томилолт	35,971,800.00	11,490,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	114,798,090.00	266,453,203.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,632,740.00	196,070,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,000,000.00	12,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,925,900.00	3,323,735.19
210804	Тээврийн хэрэгслийн татвар	725,800.00	755,724.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	166,386.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,953,300.00
210807	Газрын төлбөр	8,378,400.00	7,620,188.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	90,300.00	72,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	35,044,950.00	43,491,070.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,329,932,733.45	12,795,355,763.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,294,932,733.45	12,795,355,763.15
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	35,000,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	228,797,565.75	446,615,292.94
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	177,157,738.19	240,448,752.58
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	158,517,738.19	213,631,732.58
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,640,000.00	26,817,020.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,639,827.56	206,166,540.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,389,119.30	198,472,825.57
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,250,708.26	7,693,714.79
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	264,249,315.00	317,434,029.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	264,249,315.00	315,434,029.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	264,249,315.00	315,434,029.00
2200	Дотоод эх үүсвэрээр	264,249,315.00	315,434,029.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	264,249,315.00	315,434,029.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(264,249,315.00)	(315,434,029.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	2,000,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант он: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,974,253,679.78	15,987,156,209.98	(2,021,261,318.17)	23,940,148,571.59
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,974,253,679.78	15,987,156,209.98	(2,021,261,318.17)	23,940,148,571.59
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,574,265,276.32)	(1,574,265,276.32)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,974,253,679.78	15,987,156,209.98	(3,595,526,594.49)	22,365,883,295.27
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	508,063,056.16	508,063,056.16
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,974,253,679.78	15,987,156,209.98	(3,087,463,538.33)	22,873,946,351.43
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(508,063,056.16)	-	(508,063,056.16)
Тайлант үеийн үр дүн	-	-	7,471,048,405.81	7,471,048,405.81
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,974,253,679.78	15,479,093,153.82	4,383,584,867.48	29,836,931,701.08

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант он: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	38,959,124,700.00	35,488,956,543.15	3,470,168,156.85	91.1
УРСГАЛ ЗАРДАЛ	38,959,124,700.00	35,488,956,543.15	3,470,168,156.85	91.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,534,352,100.00	35,262,035,290.57	3,272,316,809.43	91.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,306,127,100.00	11,205,038,992.58	1,101,088,107.42	91.1
Үндсэн цалин	6,389,830,800.00	5,995,661,872.47	394,168,927.53	93.8
Нэмэгдэл	4,077,711,700.00	3,433,756,977.63	643,954,722.37	84.2
Унаа хоолны хөнгөлөлт	880,110,000.00	808,269,081.51	71,840,918.49	91.8
Урамшуулал	958,474,600.00	967,351,060.97	(8,876,460.97)	100.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,634,264,100.00	1,634,264,100.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	1,148,541,300.00	1,148,541,300.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	121,430,700.00	121,430,700.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	97,144,600.00	97,144,600.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	24,286,100.00	24,286,100.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	242,861,400.00	242,861,400.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	755,841,000.00	741,889,265.01	13,951,734.99	98.2
Гэрэл, цахилгаан	424,471,000.00	423,406,896.27	1,064,103.73	99.7
Түлш, халаалт	181,693,000.00	155,892,047.38	25,800,952.62	85.8
Цэвэр, бохир ус	149,677,000.00	162,590,321.36	(12,913,321.36)	108.6
Хангамж, бараа материалын зардал	418,782,400.00	401,843,844.17	16,938,555.83	96.0
Бичиг хэрэг	38,042,000.00	37,911,489.00	130,511.00	99.7
Тээвэр, шатахуун	54,122,000.00	52,249,350.00	1,872,650.00	96.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	26,842,000.00	27,068,543.37	(226,543.37)	100.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	157,676,500.00	156,334,198.00	1,342,302.00	99.1
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	142,099,900.00	128,280,263.80	13,819,636.20	90.3
Нормативт зардал	7,429,212,500.00	6,817,252,120.92	611,960,379.08	91.8
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,612,270,800.00	6,048,345,512.92	563,925,287.08	91.5
Хоол, хүнс	713,871,000.00	684,236,738.00	29,634,262.00	95.8
Нормын хувцас, зөөлөн эдлэл	103,070,700.00	84,669,870.00	18,400,830.00	82.1
Эд хогшил, урсгал засварын зардал	1,534,518,500.00	1,459,309,821.55	75,208,678.45	95.1
Багаж, техник, хэрэгсэл	385,262,200.00	330,126,699.00	55,135,501.00	85.7
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	35,350,400.00	34,827,200.00	523,200.00	98.5
Урсгал засвар	1,113,905,900.00	1,094,355,922.55	19,549,977.45	98.2
Томилолт, зочны зардал	25,554,000.00	11,490,000.00	14,064,000.00	45.0
Дотоод албан томилолт	25,554,000.00	11,490,000.00	14,064,000.00	45.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	217,563,300.00	217,268,223.19	295,076.81	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	156,070,400.00	156,070,400.00	-	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,000,000.00	12,000,000.00	-	100.0

Даатгалын үйлчилгээ	3,332,000.00	3,323,735.19	8,264.81	99.8
Тээврийн хэрэгслийн татвар	786,000.00	755,724.00	30,276.00	96.1
Тээврийн хэрэгслийн оношилгоо	220,000.00	166,386.00	53,614.00	75.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,953,300.00	2,953,300.00	-	100.0
Газрын төлбөр	7,625,000.00	7,620,188.00	4,812.00	99.9
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	200,000.00	72,400.00	127,600.00	36.2
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	34,376,600.00	34,306,090.00	70,510.00	99.8
Бараа үйлчилгээний бусад зардал	14,212,489,200.00	12,773,678,923.15	1,438,810,276.85	89.9
Бараа үйлчилгээний бусад зардал	14,212,489,200.00	12,773,678,923.15	1,438,810,276.85	89.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	424,772,600.00	226,921,252.58	197,851,347.42	53.4
Бусад урсгал шилжүүлэг	424,772,600.00	226,921,252.58	197,851,347.42	53.4
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	409,532,600.00	213,631,732.58	195,900,867.42	52.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,240,000.00	13,289,520.00	1,950,480.00	87.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	38,959,124,700.00	35,490,956,543.15	3,468,168,156.85	91.1
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,890,778,100.00	10,692,495,274.43	198,282,825.57	98.2
Улсын төсвөөс санхүүжих	10,890,778,100.00	10,692,495,274.43	198,282,825.57	98.2
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,965,882,900.00	20,070,726,235.00	2,895,156,665.00	87.4
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	22,965,882,900.00	20,070,726,235.00	2,895,156,665.00	87.4
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,102,463,700.00	4,727,735,033.72	374,728,666.28	92.7
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,033,844,100.00	4,633,581,636.77	400,262,463.23	92.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	68,619,600.00	94,153,396.95	(25,533,796.95)	137.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,000,000.00	(2,000,000.00)	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,525	1,419	1,419	93.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	100.0
Төсвийн байгууллага	1	1	1	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	762	709	709	93.0
Удирдах ажилтан	4	3	3	75.0
Гүйцэтгэх ажилтан	520	454	454	87.3
Үйлчлэх ажилтан	238	252	252	105.9

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант он: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	231,371,005.61
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	231,371,005.61
210	Бараа, үйлчилгээний зардал	-	210,149,790.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	38,067,515.21
210101	Үндсэн цалин	-	30,627,515.21
210104	Урамшуулал	-	7,440,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	40,134,605.61
210401	Бичиг хэрэг	-	14,710,197.61
210402	Тээвэр (шатахуун)	-	1,036,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	-	1,298,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	12,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	-	10,290,408.00
2105	Норматив зардал	-	36,416,000.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	12,500,000.00
210502	Хоол, хүнс	-	23,276,000.00
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	-	640,000.00
2106	Эд хогшил худалдан авах	-	13,028,440.00
210602	Тавилга	-	1,538,070.00
210604	Урсгал засвар	-	11,490,370.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	49,184,980.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	40,000,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	9,184,980.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	-	33,318,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	33,318,250.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	21,221,214.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	13,527,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	13,527,500.00
	Төвлөрүүлэг шилжүүлэг		7,693,714.79
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	231,371,005.61
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	231,371,005.61
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	28,060,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	128,709,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	74,602,005.61

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ерөнхий захирал Э.Галбадрах танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд орлогыг аккруэл сууриар бүртгэж, кассын орлого төвлөрүүлэлт, өндөр өртөгт, тусламж үйлчилгээний бүртгэл, худалдан авалтын цахим төлбөрийн системийн баримт, дутуу акталсан үндсэн хөрөнгө, нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2020 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор Р.Цолмон, аудитор П.Амарсанаа, Э.Энхбаатар нар хэрэгжүүлэв.

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 сарын 25-ны өдрийн 01/47 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Улсын хэмжээнд гэмтэл согогийн чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн болон лавлагаа тусламж үйлчилгээ
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд тусламж үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай;
- Сангийн сайдын 74 дүгээр тушаалаар батлагдсан Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, няравт тавих журам батлах тухай

Мөн дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахалтай холбоотой дараах Засгийн газрын тогтоолууд гарсан байна. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай Засгийн газрын 187 дугаар тогтоол;

- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 78 дугаар тогтоол;
- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 114 дүгээр тогтоол;
- Ковид-19 цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 168 дугаар тогтоол;
- Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний Засгийн газрын 183 дугаар тогтоол.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Гэмтэл согог судлалын үндэсний төв санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Гэмтэл согог судлалын үндэсний төв нь 2020 онд дотоод аудиторын томилгоо хийгээгүй тул тус байгууллагын стратеги зорилтыг хангахад дэмжлэг үзүүлэхээр дотоод хяналт, шалгалт хийгээгүй байна.

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогын 30,407,158.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 304,071.6 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,205,704.8 мянган төгрөгөөр буюу 34.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	2,000.0	2,000.0
Авлага	2,380.0	48,139.7	45,759.7
Бараа материал	1,410,718.2	1,633,460.1	222,741.3
Үндсэн хөрөнгө	20,955,164.4	28,160,869.2	7,205,704.8
Нийт хөрөнгө	22,368,263.2	29,844,469.1	7,476,205.8
Өр төлбөр	2,380.0	7,538.4	5,157.4

Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	22,365,883.2	29,836,931.7	7,471,048.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	22,368,263.2	29,844,469.1	7,476,205.8

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,000.0 мянган төгрөг нь касс дахь мөнгийг төрийн сангийн харилцах дансанд оны эцэст төвлөрүүлээгүйгээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 48,139.7 мянган төгрөг болж 45,759.7 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны татаас санхүүжилтийн авлага 2,380.0 мянган төгрөгөөр буурч, тайлант онд 7,538.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, ажилчидтай холбогдсон авлага 602.2 мянга, видео контент хийхтэй холбоотой Премьер хелт ХХК 15,000.0 мянга, Тэлмэн халиун ХХК 25,000.0 мянган төгрөгийн авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,633,460.1 мянган төгрөг болж 222,741.3 мянган төгрөгөөр өссөн нь урсгал төсвөөс 23,181,993.2 мянган төгрөгийн бараа материал тайлант онд худалдаж авсан байна. Үүнд: 15,261,241.1 мянган төгрөгийн өндөр өртөгт хэрэгсэл, 4,011,832.7 мянган төгрөгийн эм, бэлдмэл, эмийн хэрэгсэл байгаа нь нийт худалдан авсан бараа материалын 83.1 хувийг эзэлж байна.

Мөн тайланд онд 20,325,841.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас 12,503,814.6 мянган төгрөгийн өндөр өртөгт хэрэгсэл, 6,152,265.7 мянган төгрөгийн эм, бэлдмэл, эмийн хэрэгсэл байгаа нь нийт зарцуулсан бараа материалын 91.7 хувийг эзэл байна.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас шилжүүлэн өгсөн, хандив, тусламжаар хүлээн авсан, ТӨБЗГ-ын тогтоолоор эргэлтийн бус хөрөнгөөс эргэлтийн хөрөнгөд бүртгэсэн нийт 1,333,144.6 мянган төгрөг байна. Тухайлбал:

- Халдварт өвчин судлалын үндэсний төв, Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газраас маск, хамгаалах хэрэгсэл, галзуугийн илдэс, татрагийн илдэс нийт 116,457.0 мянган төгрөгийн эм, боох материал шилжүүлэн, Монгол Эм Импекс Концерн, Мөнхийн тунгаас 60,838.2 мянган төгрөгийн эм бэлдмэл хандиваар авсан байна
- Эрүүл мэндийн яамнаас эмнэлгийн жижиг багаж хэрэгсэл 57,198.0 мянган төгрөг, Мед импекс интернэшнл ХХК-иас пульсоксиметр, зайнаас халуун хэмжих төхөөрөмж 462.0 мянган төгрөгийн хэрэгсэл хандиваар авсан байна.
- Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар эрх шилжүүлэн хийгдэж буй ариутгалын тасгийн засвар, дулаан хангамж, хэрэгцээний халуун усны, дээврийн барилгын засварын материал 1,078,384.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.
- ТӨБЗГ-ын 2020 оны А-1/791 дугаар албан бичгийн дагуу “Эрүүл мэндийн яамны харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн данснаас эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэх” жагсаалтад байсан 14,993.2 мянган төгрөгийн номыг бараа материалын дансанд шилжүүлж бүртгэсэн байна. .

Тайлант онд хөрөнгө оруулалтаар их засвар хийхэд зарцуулсан материал, акталсан бараа, өндөр өртөгт хэрэгслийн зарцуулаагүй үлдэгдлийг нийлүүлэгч байгууллагуудад буцаан шилжүүлсэн нийт 3,958,090.7 мянган төгрөг байна. Тухайлбал:

- Гэмтэл согог судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын А/140 Бараа материал актлах тухай тушаалаар зөөлөн эдлэл 73,211.7 мянга, металл эдлэл 70,175.0 мянга, жижиг багаж хэрэгсэл 29,701.7 мянган, нийт 173,088.5 мянган төгрөгийн бараа материал акталсан байна.
- Зарцуулаагүй өндөр, өртөгт хэрэгсэл 2,693,040.4 мянган төгрөгийн бараа материалыг нийлүүлэгч байгууллагуудад буцаан шилжүүлсэн байна.

Оны эцэст 1,633,460.1 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байгаагаас ковид-19 цар тахлын үеийн эрүүл мэндийн салбарын бэлэн байдалтай холбоотой хамгаалах хэрэгсэл, ариутгах бодис, маск, ковид тест, эмийн шаардлагатай нөөцүүд байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 28,160,869.2 мянган төгрөг болж 7,205,704.8 мянган төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2020 оны 688, 704 дугаар тогтоолын дагуу 8,343,523.0 мянган төгрөгийн хөрөнгө акталж, ТӨБЗГ-ын 688 дугаар тогтоолоор акталсан хөрөнгийн дахин үнэлгээнээс 4,066,371.5 мянган төгрөг нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 7,537.6 мянган төгрөг болж 5,157.4 мянган төгрөгөөр өссөн нь резидент оюутны сургалтын төлбөрийн өглөг 1,597.0 мянга, ажилчидтай холбогдсон өглөг 3,879.0 мянган төгрөг нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 29,836,931.7 мянган төгрөг болж 7,471,048.4 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, хандив, тусламж, бараа материалын үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 10,710,962.6 мянган төгрөгөөр буюу 35.2 хувиар өссөн байна. Үүнд:

- Урсгал үйл ажиллагааны санхүүжилт- 2,192,538.4 мянган төгрөг,
- Үндсэн үйл ажиллагааны орлого- 1,733,147.5 мянган төгрөг,
- Туслах үйл ажиллагааны орлого- 35,490.1 мянган төгрөг,
- Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө- 3,845,807.9 мянган төгрөг,
- Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал- 1,156,301.6 мянган төгрөг,
- Хандив, тусламжийн орлого- 20,748.0 мянган төгрөг,
- Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт- 2,317,103.1 мянган төгрөг,

Нийт зардал өмнөх оноос 4,760,343.1 мянган төгрөгөөр буюу 14.9 хувиар өссөн байна. Тухайлбал:

- Цалин хөлс нэмэгдэл урамшуулал- 2,014,971.7 мянган төгрөг,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл- 255,505.6 мянган төгрөг,
- Байр ашиглалтай холбоотой зардал- 54,557.9 мянган төгрөг,
- Хангамж, бараа материалын зардал- 122,843.6 мянган төгрөг,
- Норматив зардал- 2,126,243.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь урсгал төсвөөс үндсэн үйл ажиллагаанд зарцуулах эм, бэлдмэл, эмийн хэрэгслийн зардлыг хасаад Ковид-19 цар тахлын үеийн онц бэлэн байдалд хэрэглэх хамгаалах хэрэгсэл, ариутгах бодис, маск, тест, эмийн шаардлагатай нөөц бэлтгэхтэй холбоотой зарцуулалт байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 39,470,852.51 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 748,142.3 мянган төгрөгөөр бууруулж 38,210,982.4 мянган төгрөгөөр баталсан байгаа нь эмийн зардал, тогтмол зардалтай холбоотой байна. Мөн жилийн эцэст зарцуулаагүй 206,166.5 мянган төгрөг төвлөрүүлсэн нь төсвийн төсвийн төслийг бодитой бус хийсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 38,959,124.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 10,890,778.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 22,965,882.9 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 5,033,844.1 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 68,619.6 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 10,692,305.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, эрүүл мэндийн даатгалын сангаас 20,070,726.3 мянган, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 4,727,925.0 мянган төгрөг, нийт 35,490,956.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 35,488,956.5 мянган төгрөгийг зарцуулж 206,166.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 35,488,956.5 мянган төгрөг буюу 91 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 1,101,088.1 мянга, байр ашиглалттай холбоотой зардлыг 13,951.7 мянга, хангамж, бараа материалын зардлыг 16,938.5 мянга, норматив зардлыг 611,960.3 мянга, эд хогшил, урсгал зардлыг 75,208.6 мянга, томилолт, зочны зардал 14,064.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 295.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 1,438,810.2 мянга, урсгал шилжүүлэг 197,851.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь Эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 1,833,506.5 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал 197,851.3 мянга, өндөр өртөгт мэс заслын зардал арга хэмжээ 1,438,778.7 мянга, хөтөлбөрийн төслийн дотоод урсгал 31,4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 28,060.0 мянган төгрөг, татаас санхүүжилтийн авлага 2,380.0 мянган, дээд шатны төсвийн захирагчаас 170,874.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 30,057.0 мянган, нийт 231,371.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс ДЭМБ-ийн хандив, тусламжийн санхүүжилтийг хүүхдийн эсрэг хүчирхийллийг сургуулийн орчинд эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэлт, хариу арга хэмжээ сэдэвт сургалтын зардалд 28,060.0 мянга, өмнөх оны авлагыг гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх тусламж үйлчилгээ сургалтын өдрийн хоолны зардалд 2,380.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтийг Ковид-19 цар тахлын үед иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгаа зохион байгуулах үйл ажиллагааны зардалд 40,000.0 мянга, ахмад настан унаж бэртэх эрсдэлт хүчин зүйлийг бууруулах хөтөлбөрт 28,000.0 мянган төгрөг зарцуулсан.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн резидент өмчийн сургалтын төлбөр, сургалт зохион байгуулах зардалд 46,361.6 мянга, эрүүл мэндийн яамнаас Ковид-19 цар тахлын үед ажилласан эмч, резидент нарт урамшуулал, ариутгалын бодис, хамгаалалтын бүс тогтооход 40,818.6 мянга төгрөг зарцуулсан.

УОК-оос олгосон Ковид-19 цар тахлын үед хамгаалах байрны зардалд 8,000.0 мянга, улсын мэдээллийн маягт, хог хаягдал, ариутгалын, бичиг хэргийн зардалд 30,057.0 мянга,

нийт 223,677.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 7,693.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 175 мэдээллээс хугацаандаа оруулсан 160 мэдээлэл, хугацаа хоцроосон 15 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 31,547.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 89,422.3 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 74.5 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	3,000.0	1	3,000.0	-	-	-
Албан шаардлага	1	31,547.8	1	31,547.8	-	-	-
Зөвлөмж	1	89,422.3	1	66,619.6	-	66,619.6	74.5
Нийт дүн	3	123,970.1	3	101,167.4	-	-	-

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,157,221.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,460,091.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 38,796.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 656,333.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн урсгал санхүүжилтийг 190.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг;
2. Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлгээс буцаан авах авлагыг 1.0 мянган төгрөгөөр илүү авлага үүсгэн тайлагнасныг;
3. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд 23 нэр төрлийн 33 ширхэг 1,495,031.3 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах жилийг хасах утгатай хуримтлагдсан элэгдлийг 77,949.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг;
4. Акталсан хөрөнгийн тогтоолд байхгүй автомашины бүрхүүл 470.1 мянган төгрөгийг данснаас хассан, 48,470.5 мянган төгрөгийг авто тээврийн хэрэгслийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн хэсэгт тайлагнаснаас акталж данснаас хассан хөрөнгийн дүн тодруулга тайланд дутуу илэрхийлэгдсэн;
5. Тайлант онд 16 нэр төрлийн 73,211.4 мянган төгрөгийн зөөлөн эдлэл, 55 нэр төрлийн 70,150.0 мянган төгрөгийн металл эдлэл, 134 нэр төрлийн 29,701.7 мянган төгрөгийн эмнэлгийн жижиг багаж, нийт 173,088.5 мянган төгрөгийн

- бараа материалыг актлахдаа бараа материалын дэлгэрэнгүй тайлангийн акталсан ангилалд толилуулаагүй;
6. Эрүүл мэндийн яамнаас хөрөнгө оруулалтаар шилжүүлсэн өгсөн 4,066,726.0 мянган төгрөгийн хөрөнгийг нэмэлт санхүүжилтийн орлого ангилалд бүртгэснийг;
 7. Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 17,211.5 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор давхардуулан бүртгэснийг;
 8. Үндсэн хөрөнгөөс бараа материал дансанд 14,993.2 мянган төгрөгийн номыг шилжүүлэн бүртгэхдээ 236.3 мянган төгрөгийн ажлын сандлыг хамт хасаж хөрөнгө худалдсаны гарзыг 15,229.5 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 14,993.2 мянган төгрөгөөр тус тус илэрхийлснийг;
 9. Нэмэлт санхүүжилтийн тайлангийн мөнгөн орлого зардлыг 5,940.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг;
 10. Нэмэлт санхүүжилтийн данснаас контент захиалгаар бэлтгэн нийлүүлэх гэрээгээр Прьемер хелт ХХК-д 15,000.0 мянга, Тэлмэн Халиун ХХК-д 25,000.0 мянган, нийт 40,000.0 мянган төгрөгийг шилжүүлэн, авлага үүсгээгүйг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 40,765.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 2,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 39,336.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлэв.

1. Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/392 дугаар "Санхүү бүртгэлийн ажилтнуудын ажил дүгнэх тухай" тушаалыг үндэслэн нягтлан бодох бүртгэлийн албаны ажилтнуудад олгохоор шийдвэрлэсэн балансын урамшуулал 9,017.0 мянган төгрөгийг өөр алба, тасгийн ажилтанд олгосон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно"; Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/392 тоот Санхүү бүртгэлийн ажилтнуудын ажил дүгнэх тухай" тушаалын 2-т "2020 оны хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь үнэн зөв гаргаж ажлын үр дүнгээр хангалттай үнэлгээ авсан байгууллагуудын дарга, ахлах/тооцооны/ нягтлан бодогч, эдийн засагч, нярав нарт батлагдсан төсөвтөө багтаан урамшуулал олгохыг харьяа байгууллагын төсвийн шууд захирагч нар зөвшөөрсүгэй" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

2. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс олгосон резидент оюутны сургалтын зардлаас 9,173.4 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 3,225.0 мянган төгрөгийн урсгал засвар, нийт 12,398.4 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байгаа нь Эрүүл мэндийн сайдын, Сангийн сайдын хамтарсан 2020 оны 97/56 "Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай" тушаалын 4.1.2-т "Төгсөлтийн дараах сургалтыг явуулах зөвшөөрөл бүхий байгууллага нь сургалтын төлбөрийг зөвхөн сургалтын үйл ажиллагаанд дараах жишгийг баримтлан зарцуулна" 4.1.2.1-д "Багшийн ажлын хөлсөнд 45 хувь", 4.1.2.3-д "Сургалтын материал (сургалтад хэрэглэгдэх нэг удаагийн багаж хэрэгсэл, зайлшгүй хэрэглэгдэх бусад материал, гарын авлага)-д 35 хувь", 4.1.2.4 "ЭМХТ-өөс төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаанд хянал шинжилгээ хийх, хэрэгжилтийг нэгдсэн зохион байгуулалтаар хангах, элсэлт төгсөлтийн шалгалт зохион байгуулах, үнэмлэх, гэрчилгээг хэвлүүлэхтэй холбоотой зардалд 5 хувь" гэж заасны мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3. Ковид-19 халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед эмнэлгийн 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан бүх ажилчдыг хамруулан урлаг, спортын арга хэмжээнд 17,381.1 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байгаа нь Засгийн газрын дугаар 114 дүгээр тогтоолын 3.3-д

Төсвийн урсгал зардлаас дараах зардлыг төсвийн орлого бүрдэлт болон ач холбогдолтой нь уялдуулан санхүүжүүлэх; 3.3.1-т бүх төрлийн судалгаа, тооллого, соёл урлаг, спортын чиглэлээр хэрэгжүүлэх нэг удаагийн арга хэмжээ, бүх төрлийн дэмжлэг урамшуулал, зээлийн хүүгийн татаас гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

4. Жилийн эцэст кассын орлогоос 2,000.0 мянган төгрөгийг харилцах дансанд төвлөрүүлээгүй байгаа нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан 1 хавсралт “Төсвийн байгууллагын мөнгөн кассын журам”-ын 6.1-д “Төсвийн байгууллагын кассад хэрэгцээнээс илүү мөнгө хадгалах явдлаас зайлсхийх үүднээс жижиг мөнгөн сангийн хэмжээг нарийвчлан төлөвлөж байна” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 656,333.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

1. Гэмтэл согог судлалын үндэсний төв нь 2021 оноос менежментийн бие даасан тогтолцоонд шилжиж байгаатай холбогдуулан үйл ажиллагааны шинэчлэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналын онцлог, удирдах зөвлөлийн шийдвэр гаргалт, байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй шинэчилсэн хууль, эрх зүйн орчин гэх мэт чухал асуудлууд тулгарч байгаа тул дээрх тогтолцоог бэхжүүлэх эерэг, үр нөлөө үзүүлэхүйц аудитын зөвлөмж, захиргааны акт үйлдэж ажиллах.

2. Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хумигдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх зэрэг төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал үед аудитыг хийж гүйцэтгэв.

3. Тайлант онд төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 374,728.6 мянган төгрөгөөр дутуу биелсэн байна. Түүнчлэн Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захирлын 2020 оны 12 дугаар сарын 24-ний А/143 тоот тушаалаар 30,057.0 мянган төгрөгийн давсан орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан асуудлуудыг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг аккруэл сууриар бүртгээгүйгээс 137,232.6 мянган төгрөгийн орлого бууруулж тайлагнасан байна. Мөн өндөр өртөгт тусламж үйлчилгээний бүртгэлийг аккруэл сууриар бүртгээгүйгээс төлбөрийн чадваргүй, нас барсан иргэдэд үзүүлсэн 21,649.5 мянган төгрөгийн үйлчилгээний авлагыг санхүүгийн тайлант онд тооцоо үүсдэггүй, жил бүр өндөр өртөгтийн зарцуулалтаар тайлагнагддаг байна.

1.2 Эрсдэл: Байгууллагын мөнгөн орлого цэвэр дүнгээр илэрхийлэгдэхгүй байх, бүртгэл тайланд тусгаж, эрх бүхий албан тушаалтан, удирдах зөвлөлийг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллахгүй байх.

1.3 Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоол “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-д заагаагүй орлогыг буруулж тайлагнахгүй байх, аккруэл сууриар бүртгэж санхүүгийн тайлан, бүртгэлд тусгаж ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: ТӨБЗГ-ын 2020 оны 704 дугаар тогтоол “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох тухай”, 2020 оны 688 дугаар тогтоол “Үндсэн хөрөнгийн ашиглалтыг хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох тухай” нийт 8,719,794.4 мянган төгрөгийн элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг данснаас хасах шийдвэрийг тулган шалгахад 390,013.8 мянган төгрөгөөр дутуу хассан байна. Мөн Эрүүл мэндийн яамнаас тайлант онд үнэ төлбөргүй шилжүүлэн өгсөн 37,900.0 мянган төгрөгийн шинэ фургон автомашин ашиглалтгүй байна.

2.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, дээд шатны байгууллагын тушаал шийдвэр хэрэгжихгүй байх, хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгийн үр ашиг буурах.

2.3. Өгсөн зөвлөмж: Тушаалд орсон хөрөнгийг акталж, үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох. Ашиглалтгүй хөрөнгийг эрх бүхий байгууллагад хандаж хэрэгцээ шаардлагатай газарт нь шилжүүлэх арга хэмжээ авч ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Цахим төлбөрийн баримттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Тайлант оны худалдан авалтаас 169 аж ахуй нэгжтэй хийсэн 22,001,166.2 мянган төгрөгийг түүвэрт хамруулан НӨАТ-ын и-баримтын бүртгэлийн системтэй тулган шалгахад 99 аж ахуйн нэгжээс 3,749,202.6 мянган төгрөгийн худалдан авалтын төлбөрийн цахим баримтыг гаргуулан аваагүй байна.

3.2. Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналт сул, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ их, хууль, журам мөрдөгдөхгүй байх.

3.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна. Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж

ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм гэсэн заалтын дагуу төлбөрийн баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, харилцагч байгууллагаас бүрэн гаргуулан авахад хяналт тавьж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2010 онд боловсруулсан бөгөөд уг бодлогын баримт бичигт Сангийн сайдын 2012 оны 76, 2014 оны 55, 2015 оны 7, 2019 оны 74 дүгээр тушаалуудаар баталсан журам заавар, холбогдох стандартын өөрчлөлтийг тусгаагүй байна.

4.2. Эрсдэл: Бодлогын баримт бичиг байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн онцлог бүртгэл, менежментийн бие даасан тогтолцооны санхүүгийн тайлагналтай уяалдахгүй байх.

4.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

5. Худалдан авалттай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт: Тайлант оны эм, бэлдмэл, эмийн хэрэгслийн худалдан авалт 6,179,650.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, боох материалын дэлгэрэнгүй тайлантай тулган шалгахад бараа материалын дэлгэрэнгүй тайлан нь худалдан авалтаас 1,827.5 мянган төгрөгөөр илүү байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах”-тай нийцэхгүй байна.

5.2. Эрсдэл: Эрх бүхий албан тушаалтан, удирдах зөвлөл, дээд байгууллагыг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллахгүй байх.

5.3. Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлан, бүртгэлийг үнэн зөв, бодитой толилуулах.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

6. Бараа материалтай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт: Ашиглагдах боломжгүй 2 нэр төрлийн 62,910.0 мянган төгрөгийн багаж, хэрэгсэл бараа материалын тайланд бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна” заасантай нийцэхгүй байна.

5.2. Эрсдэл: Байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материалын эвдэрч, ашиглалтгүй болох.

5.3. Өгсөн зөвлөмж: Ашиглагдахгүй байгаа 2 нэр төрлийн багаж, хэрэгслийг засаж, сэлбэх боломжгүй тул акталж, данснаас хасах.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020	Аудитын нэр: Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2020/54/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Гэмтэл согог судлалын үндэсний төв	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
		2	3	4	5
1	Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/392 дугаар "Санхүү бүртгэлийн ажилтнуудын ажил дүгнэх тухай" тушаалыг үндэслэн нягтлан бодох бүртгэлийн албаны ажилтнуудад олгохоор шийдвэрлэсэн балансын урамшууллыг өөр алба, тасгийн ажилтанд олгосон.	9,017.0	Албан шаардлага	ГССҮТ-ийн Ерөнхий захирал, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга	Э.Галбадрах, Ц.Энхбаяр
2	Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс олгосон резидент оюутны сургалтын зардлаас 9,173.4 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 3,225.0 мянган төгрөгийн урсгал засвар, нийт 12,398.4 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	12,398.4	Албан шаардлага	ГССҮТ-ийн Ерөнхий захирал, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга	Э.Галбадрах, Ц.Энхбаяр
3	Ковид-19 халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед эмнэлгийн 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан бүх ажилчдыг хамруулан урлаг, спортын арга хэмжээний зардалд 17,381.1 мянган төгрөгийн үр ашиггүй зарцуулалт гаргасан байна.	17,381.1	Албан шаардлага	ГССҮТ-ийн Ерөнхий захирал, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга	Э.Галбадрах, Ц.Энхбаяр
4	Жилийн эцэст кассын орлогоос 2,000.0 мянган төгрөгийг харилцах дансанд төвлөрүүлээгүй байна.	2,000.0	Төлбөрийн акт	ГССҮТ-ийн Ерөнхий захирал, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга	Э.Галбадрах, Ц.Энхбаяр
5	Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг аккруэл сууриар бүртгээгүйгээс 137,232.6 мянган төгрөгийн орлого бууруулж тайлагнасан байна. Мөн өндөр өртөгт тусламж үйлчилгээний бүртгэлийг аккруэл сууриар бүртгээгүйгээс төлбөрийн чадваргүй, нас барсан иргэдэд үзүүлсэн 21,649.5 мянган төгрөгийн үйлчилгээ санхүүгийн тайланд тооцоо үүсдэггүй, жил бүр өндөр өртөгийн зарцуулалтаар тайлагнагддаг байна.	158,882.1	Зөвлөмж өгөх	ГССҮТ-ийн Ерөнхий захирал, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга	Э.Галбадрах, Ц.Энхбаяр
6	ТӨБЗГ-ын 2020 оны 704 дугаар тогтоол "Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох тухай", 2020 оны 688 дугаар тогтоол "Үндсэн хөрөнгийн ашиглалтыг хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох тухай" нийт 8,719,794.4 мянган төгрөгийн элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийн данснаас хасах шийдвэрийг тулган шалгахад 390,013.8 мянган төгрөгөөр дутуу данснаас хассан байна. Мөн Эрүүл мэндийн яамнаас тайлант онд үнэ төлбөргүй шилжүүлэн өгсөн 37,900.0 мянган төгрөгийн шинэ фургон автомашин ашиглалтгүй байна.	427,913.8	Зөвлөмж өгөх	ГССҮТ-ийн Ерөнхий захирал, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга	Э.Галбадрах, Ц.Энхбаяр

7	Тайлант оны худалдан авалтаас 169 аж ахуй нэгжтэй хийсэн 22,001,166.2 мянган төгрөгийг түүвэрт хамруулан НӨАТ-ын и-баримтын бүртгэлийн системтэй тулган шалгахад 99 аж ахуйн нэгжээс 3,749,202.6 мянган төгрөгийн худалдан авалтын төлбөрийн цахим баримтыг гаргуулан аваагүй байна.	-	Зөвлөмж өгөх	ГССҮТ-ийн Ерөнхий захирал, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга	Э.Галбадрах, Ц.Энхбаяр
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2010 онд боловсруулсан бөгөөд уг бодлогын баримт бичигт Сангийн сайдын 2012 оны 76, 2014 оны 55, 2015 оны 7, 2019 оны 74 дүгээр тушаалуудаар баталсан журам заавар, холбогдох стандартын өөрчлөлтийг тусгаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	ГССҮТ-ийн Ерөнхий захирал, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга	Э.Галбадрах, Ц.Энхбаяр
9	Тайлант оны эм, бэлдмэл, эмийн хэрэгслийн худалдан авалт 6,179,650.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, боож материалын дэлгэрэнгүй тайлантай тулган шалгахад бараа материалын дэлгэрэнгүй тайлан нь худалдан авалтаас 1,827.5 мянган төгрөгөөр илүү байна.	1,827.5	Зөвлөмж өгөх	ГССҮТ-ийн Ерөнхий захирал, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга	Э.Галбадрах, Ц.Энхбаяр
10	Ашиглагдах боломжгүй 2 нэр төрлийн 62,910.0 мянган төгрөгийн багаж, хэрэгсэл бараа материалын тайланд бүртгэлтэй, хүнсний материал 2,800.0 мянга, шатахуун 2,000.0 мянган төгрөгийг шууд зардалд бүртгэсэн байна.	67,710.0	Зөвлөмж өгөх	ГССҮТ-ийн Ерөнхий захирал, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга	Э.Галбадрах, Ц.Энхбаяр
ДҮН		697,129.9			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 05

№ 46/2017-0064
САГ-2021/154/СМ-ТЭБ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцэст кассын орлогоос 2,000,000.0 /хоёр сая/ төгрөгийг харилцах дансанд төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 хавсралт Төсвийн байгууллагын мөнгөн кассын журмын 6.1-д "Төсвийн байгууллагын кассанд хэрэгцээнээс илүү мөнгө хадгалах явдлаас зайлсхийх үүднээс жижиг мөнгөн сангийн хэмжээг нарийвчлан төлөвлөж байна" гэж заасныг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Харилцах дансанд төвлөрүүлээгүй үлдэгдэл 2,000,000.0 /хоёр сая/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь Аудитын хяналт шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захирал Э.Галбадрах, Санхүү, бүртгэлийн албаны дарга Ц.Энхбаяр нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
П.АМАРСАНАА
Э.ЭНХБААТАР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 4 дугаар сарын 06

№ 163/40170064
САГ-2021/54/СГА-ТӨЛС

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ковид-19 халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед эмнэлгийн 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан бүх ажилчдыг хамруулан урлаг, спортын арга хэмжээний зардалд 17,381,100.0 /арван долоон сая гурван зуун наян нэгэн мянга нэг зуун/ төгрөгийн үр ашиггүй зарцуулалт гаргасан байна.

Засгийн газрын дугаар 114 дүгээр тогтоолын 3.3-д “Төсвийн урсгал зардлаас дараах зардлыг төсвийн орлого бүрдэлт болон ач холбогдолтой нь уялдуулан санхүүжүүлэх”; 3.3.1-т “бүх төрлийн судалгаа, тооллого, соёл урлаг, спортын чиглэлээр хэрэгжүүлэх нэг удаагийн арга хэмжээ, бүх төрлийн дэмжлэг урамшуулал, зээлийн хүүгийн татаас” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрх бүхий байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийг мөрдөж ажиллах. Биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захирал Э.Галбадрах, Санхүү, бүртгэлийн албаны дарга Ц.Энхбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
П.АМАРСАНАА
Э.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 08 дугаар сарын 25

№ 163/НТ-0064

Улаанбаатар хот

СНГ-002/54/СТН-7015

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс олгосон резидент оюутны сургалтын зардлаас 9,173,400.0 /есөн сая нэг зуун далан гурван мянга дөрвөн зуун/ төгрөгийн тавилга, эд хогшил, 3,225,000.0 /гурван сая хоёр зуун хорин таван мянган/ төгрөгийн урсгал засвар, нийт 12,398,400.0 /арван хоёр сая гурван зуун ерэн найман мянга дөрвөн зуун/ төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын, Сангийн сайдын хамтарсан 2020 оны 97/56 “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай” тушаалын 4.1.2-т “Төгсөлтийн дараах сургалтыг явуулах зөвшөөрөл бүхий байгууллага нь сургалтын төлбөрийг зөвхөн сургалтын үйл ажиллагаанд дараах жишгийг баримтлан зарцуулна” 4.1.2.1-д “Багшийн ажлын хөлсөнд 45%”, 4.1.2.3-д “Сургалтын материал (сургалтад хэрэглэгдэх нэг удаагийн багаж хэрэгсэл, зайлшгүй хэрэглэгдэх бусад материал, гарын авлага)-д 35%”, 4.1.2.4 “ЭМХТ-өөс төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаанд хянал шинжилгээ хийх, хэрэгжилтийг нэгдсэн зохион байгуулалтаар хангах, элсэлт төгсөлтийн шалгалт зохион байгуулах, үнэмлэх, гэрчилгээг хэвлүүлэхтэй холбоотой зардалд 5%” гэж заасны мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:


1. Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2020 оны 97/56 “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай” тушаалыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
3. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захирал Э.Галбадрах, Санхүү, бүртгэлийн албаны дарга Ц.Энхбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

П.АМАРСАНАА

Э.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 165/40170064
СНТ-2021/54/СТА-ТМБ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/392 тоот “Санхүү бүртгэлийн ажилтнуудын ажил дүгнэх тухай” тушаалыг үндэслэн олгохоор шийдвэрлэсэн балансын урамшуулал 9,016,875.0 /есөн сая арван зургаан мянга найман зуун далан таван/ төгрөгийг өөр алба, тасгийн ажилтнуудад олгосон байгаа нь:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно”;
2. Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/392 тоот Санхүү бүртгэлийн ажилтнуудын ажил дүгнэх тухай” тушаалын 2-т “2020 оны хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь үнэн зөв гаргаж ажлын үр дүнгээр хангалттай үнэлгээ авсан байгууллагуудын дарга, ахлах/тооцооны/ нягтлан бодогч, эдийн засагч, нярав нарт батлагдсан төсөвтөө багтаан урамшуулал олгохыг харьяа байгууллагын төсвийн шууд захирагч нар зөвшөөрсүгэй” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээд шатны төсөв захирагчийн гаргасан тушаал, шийдвэрийг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх. Биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захирал Э.Галбадрах, Санхүү, бүртгэлийн албаны дарга Ц.Энхбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
П.АМАРСАНАА
Э.ЭНХБААТАР